

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС, ЗӨВЛӨЛИЙН ЗАСАГТ  
СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ХОЛБООТ УЛС БА БҮГД НАЙРАМ-  
ДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ХООРОНД ТӨМӨР ЗАМЫН ШУУД  
ХАРИЛЦАА БАЙГУУЛАХ ТУХАЙ

Х Э Л Э Л Ц Э Э Р

Нэг талаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын Төв Засгийн Газар, нэгээ талаас Зөвлөлийн Засагт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газар ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газар хоорондоо тохиролцсоны үндсэн дээр, тус орнуудын хоорондын эдийн засаг, соёлын холбоог өргөтгэх ба төмөр замын шууд харилцааг тогтоох зорилгоор хэлэлцэн тохирсон нь:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Дээр дурдсан зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутаг дээр Цзинин (Пиндициоань)-аас Эрлянийн орчим байгаа хятад-монголын хил хүртэл, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дээр Улаанбаатараас Замын Үүдийн орчим байгаа монгол-хятадын хил хүртэл төмөр зам байгуулах тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн Газар нь Зөвлөлийн Засагт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн Газар ба Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газартай тохиролцов.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэгч Этгээдүүд нь дээр дурдсан төмөр замуудыг байгуулах явдлыг хоёр чиглэлээс нэг зэрэг гүйцэтгэхээр хэлэлцэн тохирсон бөгөөд Хятадын нутаг дээр байгуулах төмөр замыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас барьж гүйцэтгэх ба харин Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутаг дээрэхийг СССР ба БНМАУ-аас зөвлөлт-монголын хэлэлцээр ёсоор барьж гүйцэтгэхээр хэлэлцэн тохиром.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэгч Этгээдүүд нь энэ Хэлэлцээрийн нэгдүгээр зүйлд дурдсан төмөр замуудыг 1524 мм өргөн, дан замтай бөгөөд хоногт 12 хос галт тэргийг нэвтрүүлэх чадалтайгаар байгуулаад дараа уул замуудыг Хэлэлцэгч Этгээдүүдийн тохиролцсоноор хоногт 24 хос галт тэрэг нэвтрүүлэх чадалтай болгохоор хэлэлцэн тохиром.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Төмөр замын шууд харилцааг бүх шугамаар нь 1955 оны эцэст ийэсэн байхын тул уул төмөр замуудыг 1953 онд байгуулж эхлэхээр Хэлэлцэгч Этгээдүүд хэлэлцэн тохиро.

Эдгээр замын шинжилгээ ба төлөвлөгөөний ажлыг 1952 онд эхлэнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэ Хэлэлцээр нь гарын үсэг зурсан даруй хүчин төгөлдөр болно.

Энэ Хэлэлцээрийг Москва хотноо 1952 оны 9 дүгээр сарын „15“-ны өдөр, хятад, орос, монгол хэл дээр тус бүр гурван хувь үйлдсэн бөгөөд гурван эх нь цөм адил хүчинтэй болно.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ард- ын Төв Засгийн Газрын эрх олгосноор	Зөвлөлийн Засагт Социа- лист Бүгд Найрамдах Хол- боот Улсын Засгийн Газрын эрх олгосноор	Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн Газрын эрх олгосноор
--	---	---

周恩来

